



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/142/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2018 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Лүндэгмаа Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn Аудитор: Б.Эрдэнэтунгалаг Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com</p>
--	--

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
3.1	(Аудитын чиглэл).....	
3.1.1	Илрүүлэлт:.....	
3.1.2	Эрсдэл:	
3.1.3	Өгсөн зөвлөмж:	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
3.2	(Аудитын чиглэл).....	
3.2.1	Илрүүлэлт:.....	
3.2.2	Эрсдэл:	
3.2.3	Өгсөн зөвлөмж:	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,

Утас: (705) 2-27-34

2019-02-22 № 7-6/12
танай _____ -ны № _____ -т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.БАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Стандарт хэмжил зүйн хэлтсийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Н. Баярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.29-нөөс 2019.02.01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018.02.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн-Аудит ХХК-ийн аудитор Б.Эрдэнэтунгалаг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.21-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтэс нь Стандартчилал, тохирлын үнэлгээний баталгаажуулалт, хэмжил зүйн чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэн, чанарын удирдлагын тогтолцоот байгууллага болоход оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бараа бүтээгдэхүүний чанарын сорил, хяналт

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- НДШ-ийн тухай хууль
- ХХОАТатварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчлэгдсэн байна

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийдэгтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны нийт зардал 191944,8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,919.45 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дундаж хувийг сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	623,7	Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант үеийн үр дүн, санхүүгийн байдлын тайлант 1177.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: .Аудитын явцад тус зөрүүг дансны бичилтээр залруулав.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад анхаарал татахуйц асуудал илэрсэнгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 132395,5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 129929,9 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь зарим зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжээгүй шалтгаан нь төсвийн зардлын ангиллыг дахин зөрчиж зөрчил гаргасан байна.

Энэхүү зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1.1 Илрүүлэлт

Бичиг хэргийн зардлаас 2018 оны 12-р сард 623.7 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зардлын ангилал, болон Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн зардлын ангиллын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад (2019 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	190,846,620.00	199,056,525.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,962,920.00	66,649,025.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,962,920.00	66,649,025.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,962,920.00	66,649,025.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,477,920.00	65,114,025.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,485,000.00	1,535,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,883,700.00	132,407,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	109,873,700.00	132,397,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	109,873,700.00	132,397,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000.00	10,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	199,136,086.70	191,944,859.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,449,907.70	124,245,212.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,449,907.70	124,245,212.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,979,886.00	77,135,217.00
210101	Үндсэн цалин	63,555,186.00	62,331,017.00
210102	Нэмэгдэл	00.00	9,232,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,742,200.00	5,571,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,682,500.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,237,100.00	9,470,723.96
210201	Тэтгэврийн даатгал	5,241,789.00	5,823,863.96
210202	Тэтгэмжийн даатгал	748,828.00	911,440.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	599,062.00	729,570.00
210204	Ажилгүйдлийн даатгал	149,768.00	182,470.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,497,653.00	1,823,380.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,523,361.00	11,499,652.00
210301	Гэрэл, цахилгаан	690,005.00	642,952.00
210302	Тулш, халаалт	9,365,856.00	10,306,800.00
210303	Цэвэр, бохир ус	467,500.00	549,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,269,867.98	9,590,959.30
210401	Бичиг хэрэг	2,179,944.18	3,419,154.30
210402	Тээвэр, шатахуун	3,675,000.00	2,910,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	889,993.80	880,958.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	144,000.00	294,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,930.00	2,086,847.00
2105	Нормативт зардал	163,200.00	444,875.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,200.00	187,945.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	140,000.00	256,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	515,400.00	1,231,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	800,000.00
210604	Урсгал засвар	515,400.00	431,600.00
2107	Томилот, зочны зардал	5,084,500.00	7,517,600.00
210702	Дотоод албан томилот	5,084,500.00	7,517,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	496,100.00	3,229,150.00

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	291,300.00	289,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	15,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	2,720,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,180,492.72	4,125,434.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	451,000.00	1,020,542.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,000.00	171,338.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,699,492.72	2,933,554.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,686,179.00	67,699,647.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	120,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	120,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,686,179.00	67,579,647.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,686,179.00	67,579,647.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,289,466.70	7,111,665.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,289,466.70	7,111,665.90

Handwritten signatures and a red rectangular stamp with the text: 4417144353, ЕНQA0056 9025707

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	188,181,959.00	196,890,824.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,298,259.00	64,483,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	78,298,259.00	64,483,324.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,298,259.00	64,483,324.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,298,259.00	64,483,324.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,883,700.00	132,407,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	109,873,700.00	132,397,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	109,873,700.00	132,397,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000.00	10,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	188,181,959.00	194,041,124.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,181,959.00	194,041,124.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,495,780.00	126,461,477.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,657,500.00	77,601,320.00
210101	Үндсэн цалин	63,232,800.00	62,797,120.00
210102	Нэмэгдэл	00.00	11,062,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,742,200.00	3,742,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,682,500.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,102,200.00	9,819,670.00
210201	Тэтгэврийн даатгал	5,155,944.00	6,431,370.00
210202	Тэтгэмжийн даатгал	736,565.00	847,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	589,251.00	677,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	147,314.00	169,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,473,126.00	1,694,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,523,361.00	11,499,652.00
210301	Гэрэл, цахилгаан	690,005.00	642,952.00
210302	Түлш, халаалт	9,365,856.00	10,306,800.00
210303	Цэвэр, бохир ус	467,500.00	549,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,319,219.00	8,603,300.00
210401	Бичиг хэрэг	664,995.20	1,225,697.00
210402	Тээвэр, шатахуун	2,364,000.00	5,364,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	889,993.80	879,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	302,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	256,230.00	830,803.00
2105	Нормативт зардал	495,000.00	494,945.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	197,945.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	297,000.00	297,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	495,000.00	1,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	800,000.00
210604	Урсгал засвар	495,000.00	1,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	5,667,800.00	10,967,400.00
210702	Дотоод албан томилолт	5,667,800.00	10,967,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	583,600.00	3,531,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	100,000.00

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	291,300.00	289,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	15,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	148,500.00	3,083,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	652,100.00	2,143,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	547,000.00	1,547,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,100.00	596,340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,686,179.00	67,579,647.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,686,179.00	67,579,647.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,686,179.00	67,579,647.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,849,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	2,849,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,849,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,849,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,849,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-2,849,700.00




Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-62,798,881.38	17,749,238.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-62,798,881.38	17,749,238.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,289,466.70	-8,289,466.70
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-71,087,198.08	9,460,921.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-71,087,198.08	9,460,921.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,111,665.90	7,111,665.90
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,033,794.00	514,325.87	-63,975,532.18	16,572,587.69



Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Стандарт, хэмжилзүйн хэлтэс оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,397,500.00	196,880,824.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,397,500.00	196,880,824.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,397,500.00	129,311,177.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,530,600.00	77,601,320.00
210101	Үндсэн цалин	64,726,400.00	62,797,120.00
210102	Нэмэгдэл	11,062,000.00	11,062,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,742,200.00	3,742,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,164,500.00	9,819,670.00
210201	Тэтгэврийн даатгал	6,776,200.00	6,431,370.00
210202	Тэтгэмжийн даатгал	847,000.00	847,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	677,700.00	677,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	169,500.00	169,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,694,100.00	1,694,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,942,300.00	11,499,652.00
210301	Гэрэл, цахилгаан	1,085,600.00	642,952.00
210302	Түлш, халаалт	10,306,800.00	10,306,800.00
210303	Цэвэр, бохир ус	549,900.00	549,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,453,000.00	11,453,000.00
210401	Бичиг хэрэг	1,840,100.00	1,839,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,364,000.00	5,364,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	879,200.00	879,200.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	302,900.00	302,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,066,800.00	3,066,800.00
2105	Нормативт зардал	495,000.00	494,945.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	197,945.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	297,000.00	297,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	1,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,967,800.00	10,967,400.00
210702	Дотоод албан томилолт	10,967,800.00	10,967,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,592,200.00	3,531,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	289,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	15,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,083,200.00	3,083,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2452100.00	2143340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,547,000.00	1,547,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	905,100.00	596,340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	67569647.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	67,569,647.00